



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Жаргалсайханы ЗОЛЖАРГАЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-64-55, Факс: 32-70-16
E-mail: zoljargal.j@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026 06 17 № УИХ-03/7146
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.


Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Ж.ЗОЛЖАРГАЛ



2026000438



Ж.АЛДАРЖАВХЛАН

О.АЛТАНГЭРЭЛ

Н.АЛТАНХУЯГ

Н.АЛТАНШАГАЙ

Д.АМАРБАЯСГАЛАН

С.АМАРСАЙХАН

О.АМГАЛАНБААТАР

Ч.АНАР

А.АРИУНЗАЯА

Т.АУБАКИР

Х.БААСАНЖАРГАЛ

Ц.БААТАРХҮҮ

М.БАДАМСҮРЭН

Э.БАТ-АМГАЛАН

Б.БАТБААТАР

Д.БАТБАЯР

Р.БАТБОЛД

Ж.БАТЖАРГАЛ

Д.БАТЛУТ

О.БАТНАЙРАМДАЛ

Н.БАТСҮМБЭРЭЛ

Ж.БАТСУУРЬ

Х.БАТТУЛГА

Б.БАТЦЭЦЭГ

П.БАТЧИМЭГ

Э.БАТШУГАР



Ж.БАТ-ЭРДЭНЭ

Б.БАТ-ЭРДЭНЭ

Б.БАЯРБААТАР

Ж.БАЯРМАА

Ж.БАЯСГАЛАН

Б.БЕЙСЕН

Х.БОЛОРМАА

Э.БОЛОРМАА

Х.БУЛГАНТУЯА

Д.БУМ-ОЧИР

Ш.БЯМБАСҮРЭН

С.БЯМБАЦОГТ

Ж.ГАЛБАДРАХ

А.ГАНБААТАР

Г.ГАНБААТАР

Ж.ГАНБААТАР

С.ГАНБААТАР

Д.ГАНБАТ

П.ГАНЗОРИГ

Д.ГАНМАА

Л.ГАНТӨМӨР

М.ГАНХҮЛЭГ

Х.ГАНХУЯГ

Ц.ДАВААСҮРЭН

Г.ДАМДИННЯМ

Т.ДОРЖХАНД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Б.ЖАВХЛАН



Х.ЖАНГАБЫЛ

Б.ЖАРГАЛАН

Д.ЖАРГАЛСАЙХАН

С.ЗАМИРА



Б.ЗАЯАБАЛ

Ц.ИДЭРБАТ

Ч.ЛОДОЙСАМБУУ

Г.ЛУВСАНЖАМЦ

С.ЛҮНДЭГ

М.МАНДХАЙ



Л.МӨНХБААТАР

Ц.МӨНХБАТ

Л.МӨНХБАЯСГАЛАН

Т.МӨНХСАЙХАН



Б.МӨНХСОЁЛ

П.МӨНХТУЛГА

Ц.МӨНХТУЯА

З.МЭНДСАЙХАН

Б.НАЙДАЛАА

Н.НАРАНБААТАР

П.НАРАНБАЯР



М.НАРАНТУЯА-НАРА

Ч.НОМИН

О.НОМИНЧИМЭГ

2026000439

Н.НОМТОЙБАЯР

Э.ОДБАЯР

С.ОДОНТУЯА

У.ОТГОНБАЯР

Г.ОЧИРБАТ

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ПУНСАЛМАА

Д.ПҮРЭВДАВАА

Б.ПҮРЭВДОРЖ

Д.РЭГДЭЛ

П.САЙНЗОРИГ

Ц.САНДАГ-ОЧИР

О.САРАНЧУЛУУН

М.САРНАЙ

Л.СОРОНЗОНБОЛД

Р.СЭДДОРЖ

Ц.ТУВААН

Б.ТҮВШИН

Б.ТУЛГА

Х.ТЭМҮҮЖИН

Г.ТЭМҮҮЛЭН

А.УНДРАА

Ч.УНДРАМ

Д.ҮҮРИЙНТУЯА

Н.УЧРАЛ

Б.УЯНГА

2026000439

Г.УЯНГАХИШИГ

Г.ХОСБАЯР

Б.ХЭРЛЭН

Дав.ЦОГТБААТАР

Дам.ЦОГТБААТАР

О.ЦОГТГЭРЭЛ

С.ЦЭНГҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Ө.ШИЖИР

Л.ЭНХ-АМГАЛАН

Б.ЭНХБАЯР

Ж.ЭНХБАЯР

Л.ЭНХНАСАН

Д.ЭНХТҮВШИН

Д.ЭНХТУЯА

М.ЭНХЦЭЦЭГ

С.ЭРДЭНЭБАТ

С.ЭРДЭНЭБОЛД

Р.ЭРДЭНЭБҮРЭН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Жаргалсайханы ЗОЛЖАРГАЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-64-55, Факс: 32-70-16
E-mail: zoljargal.j@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.05.29 № 742-03/6249
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тов
тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулга, холбогдох тайланг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Ж.ЗОЛЖАРГАЛ

2026000397

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 9 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“9.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын санаачлан боловсруулсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын санаачлан боловсруулсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь төрийн цахим шилжилтийн бодлого, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлд нийцэж байгаа боловч зарим зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжтой уялдуулах, нэр томьёо, шаардлагыг тодорхой болгох нь зүйтэй байна.

Тухайлбал, Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.1.5 дахь заалтад хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт тусгахдаа захиргааны хэм хэмжээний акт батлах байгууллага, албан тушаалтныг тодорхойлсон байхаар заасан.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд “Нийтийн өргөдлийг цахим системээр хүлээн авах үлгэрчилсэн журмыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга батална” гэж заасан нь аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тус бүр үлгэрчилсэн журмыг баталж мөрдүүлэх агуулгатай байх бөгөөд энэ тохиолдолд уг журмын агуулга, хэрэгжилтийн хувьд нэгдмэл байдал алдагдаж, ойлголтын зөрүү үүсгэх эрсдэлтэй байна.

Иймд уг үлгэрчилсэн журмыг улсын хэмжээнд нэг мөр хэрэглэх боломжийг хангах үүднээс эрх бүхий нэг л албан тушаалтан, эсхүл Засгийн газраас баталдаг байхаар тусгах нь зүйтэй;

2.Хуулийн төслийн 2 дугаар зүйлд “Нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.3-т заасан тоон гарын үсгээр эсхүл танилт нэвтрэлтийн ДАН системээр баталгаажсан байна.” гэж тусгажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 217 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрөөс хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх үед хүн, хуулийн этгээдийг таних хэрэгсэл”-д тодорхойлсон 6 төрлийн таних хэрэгслээс зөвхөн тоон гарын үсэг, биометрик өгөгдлийг ашиглах тохиолдолд танилт, нэвтрэлтээс гадна баталгаажуулалт хийхээр тогтоосон.

Мөн танилт, нэвтрэлтийн ДАН систем нь нэг удаагийн код, банкны эрх, тоон гарын үсэг гэсэн 3 сонголтоор иргэнийг таньж байгаа бөгөөд иргэн нэг удаагийн код, банкны эрхээр нэвтрэн өргөдөл гаргах тохиолдолд өргөдлийг баталгаажуулах үйлдэл хийгдэхгүй тул хуулийн төслөөс "... эсхүл танилт нэвтрэлтийн ДАН системээр" гэснийг хасах саналтай байна.

Түүнчлэн, цахим болон хосолмол хэлбэрээр иргэдийн Нийтийн Хуралд оролцох боломжийг бүрдүүлснээр иргэдийн хувийн мэдээлэл, оролцоо, өгсөн санал цахим системд хадгалагдаж, орон нутгийн шийдвэр гаргахад нөлөөлөх өгөгдөл цахим системд төвлөрөх тул мэдээллийн аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах нь зүйтэй;

3.Хуулийн төсөлд Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгээс боловсруулсан харьцуулсан судалгааг хавсаргасан боловч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгаа, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн тайланг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан аргачлалын дагуу боловсруулж ирүүлээгүй байна.


Хуулийн төсөлд тусгасан иргэдийн Нийтийн Хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах, иргэд цахим систем ашиглан хуралд оролцох, санал өгөх боломж бүрдүүлэхийг сум, дүүргийн Засаг дарга нарт даалгахтай холбоотойгоор төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх судалгаа, тооцоог хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх заалтад "Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газар, Засаг даргын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байх" гэж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт "Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн санаачилсан хууль тогтоомжийн төслөө түүний үзэл баримтлал, танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан, эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлангийн хамт санал, дүгнэлт авахаар Засгийн газарт хүргүүлнэ" гэж тус тус заасан шаардлагыг хангаагүй болохыг анхаарах нь зүйтэй.

Түүнчлэн, орон нутагт буюу багийн иргэдийн Нийтийн Хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах боломж бололцоо, орон нутгийн тулгамдсан буюу онц чухал шаардлага, ач холбогдолтой асуудлыг цахим хурал зохион байгуулан шийдвэрлэсний улмаас гарах үр дагавар, маргааныг хэрхэн шийдвэрлэх зэргийг тооцоолоогүй, энэ талаар хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлалд дурдаагүй байна;

4.Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай талаар хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан боловч эдгээр хуулийн төслүүдийг хамтад нь боловсруулж ирүүлээгүй байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, тэдгээрийг дагаж гарах шийдвэрийн төслийг хамт боловсруулах шаардлагыг хангаагүй байна;

5.Хуулийн төсөл нь “Аргачлал батлах тухай” Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан хуулийн төслийн эх бичвэрийг боловсруулахад тавих шаардлага болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төслийн эх бичвэрт тавигдах нийтлэг шаардлагыг хангахгүй байгааг дурдах нь зүйтэй.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.03.17 № ХТ/875
танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000265003911

БАТЛАВ:

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.ЗОЛЖАРГАЛ

2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ,
ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "...1.Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.",

Арванзургаадугаар зүйлийн 9 дэх хэсэгт "шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй..", Арванзургаадугаар зүйлийн 12 дох хэсэгт "төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй", Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна." гэж тус тус заасан.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.2 дох зорилтыг хэрэгжүүлэх I үе шатанд "I үе шат (2021-2030): Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн зааг, ялгааг оновчтой тодорхойлж, оролцоог зохистой хангасан, иргэдээ сонсдог, хувийн хэвшилтэйгээ хамтарч ажилладаг тогтолцоог төлөвшүүлэх үе." хэсгийн 4 дэх заалтад "Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоо хангагдаж, хамтын ажиллагаа бэхжих нөхцөл бүрдэнэ.", 5.3 дах зорилтыг хэрэгжүүлэх I үе шатанд "I үе шат (2021-2030): Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлэх үе." хэсгийн 5 дах заалтад "Төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл явцад иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөл бүрдэж, мэдээллийн ил тод байдал нэмэгдэнэ." гэж тус тус заасан.

Мөн, 9.4 дэх зорилтыг хэрэгжүүлэх I үе шатанд "I үе шат (2021-2030): Хууль, эрх зүйн шинэчлэл хийж хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэн хотын засаглал, эдийн

засаг, нийгмийн таатай орчин бүрдүүлэх үе.” хэсгийн 1 дэх заалтад “Хотын засаглалын оновчтой тогтолцоог бүрдүүлэн бүх шатны төлөвлөлт, төлөвлөгөөг боловсруулах, батлах, шийдвэр гаргахад иргэд, олон нийтийн оролцоог хангаж, иргэдийн мэдээлэл олж авах сувгийг нээлттэй, хүртээмжтэй, ил тод болгосон байна.” мөн хэсгийн 2 дох заалтад “Хотын засаглалд төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил болон олон нийтийн оролцоо, түншлэлийг бэхжүүлэх, хувийн хэвшлээс нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийг дэмжинэ.” гэж тус тус заажээ.

Түүнчлэн, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 1.1-д “1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх зарчмыг хангах, иргэд орон нутгийн үйл хэрэгт шууд болон сонгож байгуулсан төлөөллийн байгууллагаараа уламжлан оролцох эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд оршино.” 12.1.6 -д “12.1.6.нутгийн өөрийн удирдлага нь тухайн нэгжид оршин суугаа иргэдийн хүсэл зоригийг илэрхийлж, иргэдийн саналыг харгалзан үздэг байх”, 13.1-д “13.1.Аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудлыг тухайн орон нутгийн эдийн засгийн бүтэц, чадавх, хүн амын болон газар зүйн байршил, тэдгээртэй холбогдох бусад нөхцөлийг харгалзан тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.” 13.3-д “13.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг шийдвэрлэхдээ тухайн нэгжийн иргэдийн саналыг авсан байна. Санал авах ажлыг харьяалах иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хариуцан зохион байгуулах бөгөөд санал авах журмыг Улсын Их Хурал тогтооно. Санал хураалтад сонгуулийн эрх бүхий иргэдийн олонх оролцсон бол уг санал авах ажлын дүнг хүчинтэйд тооцно.” 13.6-д “13.6.Баг, хороог өөрчлөхдөө тухайн баг, хорооны иргэдийн саналыг авах болон санал авах ажлыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зохион байгуулна.” 16.4-д “16.4.Сум, дүүргийн төсвийг боловсруулж, батлахдаа харьяалах баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлаас гаргасан саналыг авч тусгана.” 23.1.2-д “23.1.2.хууль тогтоомжид заасан болон өөрийн санаачилсан асуудлаар нутаг дэвсгэрийнхээ иргэдийн нийтлэг санал, хүсэлтийг зохих шатны байгууллага, албан тушаалтанд уламжлах ажлын зохион байгуулалт;”, 26.1.2-д “26.1.2.хууль тогтоомжид заасан болон өөрийн санаачилсан асуудлаар нутаг дэвсгэрийнхээ иргэдийн нийтлэг санал, хүсэлтийг зохих шатны байгууллага, албан тушаалтанд уламжлах ажлын зохион байгуулалт;”, 29.2-д “29.2.Иргэн аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдох, төлөөлөгчийг сонгох, баг, хорооны Иргэдийн Нийтийн Хуралд өөрөө оролцох, нутгийн өөрийн удирдлагын байгууллагад өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, хууль тогтоомжид заасан журмын дагуу мэдээлэл авах эрхтэй.” 39.1.8-д “39.1.8.сонгогчидтой тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлан хариуг хуульд заасан хугацаанд авах”, 52.1.9-д “52.1.9.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн Хуралд ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах”, 61.1.3-д “61.1.3.хорооны эдийн засаг, нийгмийн

амьдралын тодорхой асуудлаар хорооны иргэдийн саналыг авах арга хэмжээг зохион байгуулах, дүнг нэгтгэн гаргах;”, 61.1.5-д “61.1.5.энэ хуулийн 26.1.5-д заасан асуудлаар Иргэдийн Нийтийн Хурлаас зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд хорооны иргэдийг оролцуулах арга хэмжээг зохион байгуулах;”, 61.1.10-д “61.1.10.хүн амын хүнс, худалдаа, үйлчилгээ, цахилгаан, дулаан хангамжийн зохион байгуулалт, хүртээмжид хяналт тавьж, түүнийг сайжруулах талаар иргэдээс гарсан санал, хүсэлтийг холбогдох байгууллагад уламжлах;”, 61.1.15-д “61.1.15.иргэдийн өргөдөл, санал, гомдлыг хүлээн авч эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх, холбогдох байгууллагад уламжлах”, 67.1.5-д “67.1.5.тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах”, 61.1.17-д “61.1.17.гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, энэ ажилд иргэдийг татан оролцуулах, санал, санаачилгыг нь дэмжих;” гэж тус тус заажээ.

Иргэд орон нутгийн асуудалд шууд болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан оролцох эрхийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого зэрэг эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдэд тодорхойлон заажээ. Гэтэл иргэдийн оролцооны хуульд заасан хэлбэрүүд тогтмол, үр нөлөөтэй хэрэгждэггүй, цахим оролцооны нэгдсэн платформ, тогтолцоо бүрдээгүй, төрийн байгууллагын ил тод байдал, мэдээллийн хүртээмж хангалтгүй, иргэдийн санал, санаачилгыг шийдвэр гаргалтад тусгах, эрхээ эдлэх боломжийг бүрдүүлэх асуудал дутмаг байсаар байгаа нь энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль зүйн үндэслэл болж байна.

1.2.Практик шаардлага

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулга нь иргэд орон нутгийн асуудалд шууд оролцох эрх зүйн үндсийг өмнөх хуультай харьцуулахад илүү тодорхой болгож, нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэх иргэний эрх, оролцоо болон оролцох хэлбэрүүдийг өргөжүүлэн тусгасан байна. Тухайлбал, иргэдийн нийтийн хурал, санал асуулга, төсвийн төлөвлөлтөд оролцох, орон нутгийн хөгжлийн бодлогод саналаа өгөх, мэдээлэл авах ил тод байдлыг нэмэгдүүлэх зэрэг олон механизмуудыг хуульчилсан нь орон нутгийн засаглалыг ардчилсан, хариуцлагатай болгох чиглэлд ахиц авчирсан гэж үзэх боломжтой.

Шинэчилсэн найруулгын 28-31 дүгээр зүйлүүд нь нутаг дэвсгэрийн өөрийн удирдлагын үндэс болох нутгийн өөрөө удирдах ёсыг тодорхойлж, иргэдийн оролцооны эрх, хэлбэр, механизмд чиглэсэн байдаг. Эдгээр зүйлүүд нь Монгол Улсын Үндсэн хуулийн иргэдийн эрх, ардчиллын зарчим, түүний үндсэн агуулгатай уялдуулан орон нутгийн бие даасан шийдвэр гаргах эрх, иргэдийн шууд болон төлөөллийн оролцоог баталгаажуулдаг.

28 дугаар зүйл нь “нутгийн өөрөө удирдах ёс”-ыг тодорхойлсон үндсэн заалт юм. Энэ заалтаар иргэдийн эрхийг тодорхойлохоос гадна санхүү, нөөц, механизмуудтай холбоотойгоор тэдний бие даан шийдвэрлэх бодит чадварыг тодорхойлжээ. 29 дүгээр зүйл нь Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн шууд болон төлөөллийн оролцооны эрх буюу сонгох, сонгогдох, орон нутгийн асуудлаар санал гарган шууд оролцох, өргөдөл гомдлоо шийдвэрлүүлэх, мэдээлэл авах эрхүүдийг тодорхойлсон байдаг. 30 дугаар зүйлд шууд ардчиллын зарчмыг хэрэгжүүлж баг, хорооны ИНХ-д саналаа хэлэх, тодорхой асуудлаар санал гарган ИТХ-аар хэлэлцүүлэх, тулгамдсан асуудлаар санаачилга гаргах зэрэг нутгийн өөрийн удирдлагад оролцох төлөөллийн хэлбэрүүдийг тодорхойлсон. 31 дүгээр зүйл нь нутгийн өөрийн удирдлага дахь иргэний оролцоо, ИТХ, ИНХ зэрэг нутгийн өөрөө удирдах байгууллагуудын үүрэг, иргэдийн санал, санаачилга гаргах механизмууд, зөвлөлдөх санал асуулга явуулах зэргээр иргэдийн оролцоог хууль эрх зүйн механизмтай болгож, шууд ардчиллыг бэхжүүлсэн байдаг.

Ийнхүү хуульд иргэдийн оролцоог илүү нарийвчилж тодорхой болгосон нь өмнөх зохицуулалтуудаас ахицтай боловч энэхүү эрх зүйн боломж бодит амьдрал дээр бүрэн хэрэгжихгүй, “цаасан дээрх амьгүй заалт” хэвээр байсаар байна. Энэ нь иргэдийн оролцоог хангах бодит хэрэгжилтийн механизм, арга зам, цахим болон институцийн платформыг бүрдүүлж өгөөгүй байгаатай холбоотой гэж үзэж байна.

А.Иргэд оршин суугаа нэгжийнхээ эдийн засаг, нийгмийн тулгамдсан, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар нийтийн өргөдөл гаргах эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай байна.

Иргэд оршин суугаа нэгжийнхээ эдийн засаг, нийгмийн тулгамдсан, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар нийтийн өргөдөл гаргах нь орон нутгийн засаглалд шууд оролцох боломжийг бий болгож, тухайн орон нутгийн шийдвэр гаргалт, үйл ажиллагаанд иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой. Гэтэл иргэд Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зорилготой <https://petition.parliament.mn> цахим талбар дээр нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэр, хэм хэмжээний актыг эсэргүүцэн өргөдөл гаргах болсон нь хууль эрхзүйн хувьд зөв биш юм. Учир нь орон нутгийн байгууллагаас гарч буй шийдвэр нь Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудал биш бөгөөд Улсын Их Хурал тухайн шийдвэрийг шууд өөрчлөх боломжгүй байдаг.

Орон нутгийн түвшинд нийтийн өргөдөл гаргах нь орон нутгийн хөгжлийг дэмжих, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, засаглалын ил тод байдлыг хангах, шийдвэр гаргах процессийг сайжруулах, иргэдийн улс төрийн идэвх, нийгмийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой. Учир нь иргэд өдөр тутмын амьдралдаа тулгамдсан асуудлыг хамгийн сайн мэддэг бөгөөд тэдний санаачилга нь шийдвэрийг бодитой, хэрэгцээнд нийцсэн байдлаар боловсруулах боломжийг нэмэгдүүлдэг.

Нийтийн өргөдөл гаргах үйл ажиллагааг доорх байдлаар хуульчлан зохион байгуулах шаардлагатай. Нэгдүгээрт, нийтийн өргөдөл хүлээн авах, нийтлэх, санал авах, өргөдлийн агуулга, явцыг хянах зорилгоор цахим платформыг бий болгон ашиглах, хоёрдугаарт, нийтийн өргөдлийг нутгийн ИТХ-ын болон ИНХ-ын хуралдаан, зөвлөлдөх үйл ажиллагаанд танилцуулж орон нутгийн түвшний шийдвэр гаргах механизмд оруулах, гуравдугаарт, тухайн асуудлыг судлах, санал дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах, дөрөвдүгээрт, иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх, өргөдөл гаргах эрх, процедурын талаар мэдээлэл өгөх сургалт зохион байгуулах, гарын авлага боловсруулан түгээх нь чухал юм.

Б.Нутгийн өөрөө удирдах байгууллагад нийтийн өргөдөл гаргах зорилгоор нэгдсэн цахим платформ хөгжүүлэх шаардлага бий болж байна.

Монгол Улсад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, засаглалын ил тод байдал, шийдвэр гаргах процессын үр нөлөөг сайжруулах зорилгоор нэгдсэн цахим платформ хөгжүүлэх нь төрийн үйл ажиллагааг илүү ил тод, хүртээмжтэй болгох чухал алхам болно. Энэхүү платформыг одоогийн E-Mongolia системийг өргөтгөх, <https://petition.parliament.mn> вебийг өргөтгөх эсвэл эдгээрт суурилсан шинэ веб, шинэ аппликэйшн хэлбэрээр (жишээ нь, “D-Participation”) боловсруулан, иргэдийг орон нутгийн шийдвэр гаргалтад шууд оролцуулах буюу нийтийн өргөдөл гаргах, санал асуулга зохион байгуулахад чиглүүлнэ.

В.Олон улсын практик туршлагаас харахад цахим оролцооны механизм нь иргэдийн оролцооны хамрах хүрээг өргөжүүлж, шийдвэр гаргах үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлага, үр нөлөөг бодитоор сайжруулж байна.

Цахим оролцооны платформууд нь иргэдийн санал, санаачилгыг институцийн түвшинд хүлээн авч боловсруулах боломжийг бүрдүүлснээр бодлого боловсруулах, төсөв хэлэлцэх, хуваарилах, хот төлөвлөлт болон салбарын шинэчлэлийн үйл явцад иргэдийн шууд оролцоог системтэйгээр шингээх нөхцөлийг бүрдүүлжээ. Хэдийгээр эдгээр платформуудын зорилго, оролцооны хэлбэр харилцан адилгүй боловч нийтлэгээр иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд олон нийтийн саналыг бодитойгоор тусгах институцийн механизм болгон хэрэгжиж, тоон үзүүлэлтээр баталгаажихуйц эерэг үр дүнг бий болгож байна.

- Бразилд “Brasil Participativo” платформоор цугларсан 8,254 саналаас 76.5 хувь нь “Үндэсний хөгжлийн төлөвлөгөө 2024–2027”-д бүрэн буюу хэсэгчлэн тусгагдсан нь үндэсний хөгжлийн зорилт, тэргүүлэх чиглэлийг иргэдийн оролцоотой тодорхойлсон тод жишээ юм.
- Исланд Улсын Рейкьявикт “Better Reykjavík” платформоор дамжин 3,000 гаруй санал мэргэжлийн үнэлгээгээр хэлэлцэгдэж, 1,000 орчим нь “хэрэгжүүлэх санал” болж, “Миний амьдрах орчин” оролцооны төсвөөр

дамжин 600 гаруй санаачилга санхүүжигдсэн нь хотын дэд бүтэц, нийтийн орон зайн сайжруулалтад бодит, хэмжигдэхүйц үр дүн бий болгожээ.

- Барселона хотын “Decidim.barcelona” платформ нь “Хотын үйл ажиллагааны төлөвлөгөө” болон оролцооны төсөвт ирсэн саналуудын ойролцоогоор 72 хувийг тодорхой хэмжээгээр төлөвлөгөөнд оруулж, стратеги төлөвлөгөө, дүрэм журам, салбарын бодлогод иргэдийн оролцоог институцийн түвшинд байнгын оролцоотой болгосон байна.
- Испани Улсын нээлттэй эхийн “Decidim” программыг Европ болон Америк тивийн олон хот, байгууллагад хуулбарлан ашиглаж буй бол Исланд Улсын “Citizens Foundation”-ийн боловсруулсан “Your Priorities” нээлттэй эхийн программыг Исланд болон олон улсад бодлогын зөвлөлдөх, төсвийн оролцооны төсөлд өргөнөөр ашиглаж байна.
- Энэтхэгийн “MyGov” платформ нь хэрэглэгчийн тоо, оролцооны давтамжаар дэлхийн хамгийн том платформ болж, боловсролын шинэ бодлого, татварын шинэчлэл зэрэгт олон арван мянган санал нэгтгэж, мөн үндэсний хэмжээний кампанит ажилд иргэдийн улс төр-нийгмийн оролцоог идэвхжүүлж байна.

Дээрх бодит нөхцөл байдал, судалгаа болон олон улсын туршлагаас харахад иргэдийн оролцоог бодитой хангахын тулд хуульд цахим хурал, цахим нийтийн өргөдөл, оролцоог баталгаажуулах тогтолцоог тодорхой тусгах зайлшгүй шаардлага үүсэж байна. Ингэснээр иргэдийн оролцоо нь хуульд заасан зарчим төдий бус, орон нутгийн засаглалын өдөр тутмын бодит үйл ажиллагааны салшгүй хэсэг болох боломж бүрдэнэ. Иймд энэхүү хуулийн нэмэлт өөрчлөлт нь зөвхөн эрх зүйн төдийгүй практик хэрэгцээнээс урган гарч байгаа бөгөөд иргэдийн оролцоог нутгийн өөрөө удирдах байгууллагад тусгах нөхцлийг бий болгож байна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль¹-ийн 24 дүгээр зүйлд заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулав. Хуулийн төсөл нь иргэд болон нутгийн өөрийн удирдлагын байгууллага хоорондын харилцааг цахимжуулах, иргэд нийтийн өргөдөл гаргах процессыг зохицуулсан нийт 2 зүйл, 12 заалттай бөгөөд нэмэлт оруулах, өөрчлөн найруулах, мөрдөх хугацаа заасан бүтэцтэй байна.

- Иргэд тулгамдсан асуудлаар нийтийн өргөдөл гаргаж, хангалттай тооны иргэн дэмжвэл Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Иргэдийн Нийтийн Хурал заавал хэлэлцэх институтийг бий болгож байна;

¹ 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт, өөрчлөлт орсон Хууль тогтоомжийн тухай Монгол Улсын хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

- Цахим танилт, тоон гарын үсгийг нийтийн өргөдөл болон ИНХ-д албан ёсоор ашиглах эрх зүйн үндсийг тавьж байна;

Хуулийн төсөл нь Монгол Улсын бүх засаг захиргааны нэгжийг хамрах ба 18 насанд хүрсэн сонгуулийн эрх бүхий иргэдэд хамаарна. Зохицуулах хүрээ нь нутгийн өөрийн удирдлагын эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар хязгаарлагдсан бөгөөд Иргэдийн Нийтийн Хурал, ИТХ-ын бүрэн эрхэд хамаарах асуудлуудыг зохицуулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах үр дагавар гарна гэж үзэж байна:

3.1. Эдийн засгийн үр дагавар

Цахим оролцоо нэвтэрснээр орон нутгийн түвшинд шийдвэр гаргах үйл явц хурдасч, иргэдийн цаг, зардал хэмнэгдэнэ. Өргөдлийн систем нь нөөцийг илүү үр ашигтай хуваарилахад дэмжлэг үзүүлнэ. Иргэд дэд бүтэц, хөдөө аж ахуй зэрэг эдийн засгийн тулгамдсан асуудлаар санал, өргөдөл гаргаснаар бодлого бодит хэрэгцээнд илүү нийцэж, эдийн засгийн өсөлтийг дэмжих нөхцөл бүрдэнэ.

3.2. Нийгмийн үр дагавар

Иргэдийн оролцоо бодитой нэмэгдэж, орон нутгийн ардчилал бэхжинэ. Иргэдийн шууд ардчилал бэхжиж, орон нутгийн асуудлаар өргөдөл гаргах боломж нэмэгдсэнээр нийгмийн идэвх, улс төрийн соёл сайжирна. Хөдөөгийн малчид, эмэгтэйчүүд, залуучуудын оролцоо өсөж, нийгмийн тэгш байдал, төрд итгэх итгэл нэмэгдэнэ.

3.3. Хууль зүйн үр дагавар

Ил тод, хүртээмжтэй засаглалыг дэмжих эрх зүйн орчин бүрдэж, иргэдийн оролцох эрх өргөжнө. Энэ нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9, 12 дох хэсэгт заасан “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрх”, “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх”-тэй нийцэж, орон нутгийн засаг захиргааны үр нөлөө, ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэн хуулийн хэрэгжилт, хяналтыг бэхжүүлнэ.

Үр дагаврыг шийдвэрлэх арга хэмжээ:

- Цахим засаг үндэсний хөтөлбөр, цахим засаглалын хөгжлийн бодлогыг ашиглан иргэдэд ээлтэй, нэгдсэн цахим системийг хөгжүүлж, алслагдсан бүс нутгийн интернетийн хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Цахим платформыг одоогийн E-Mongolia системийг өргөтгөх эсвэл <https://petition.parliament.mn> вебийг өргөтгөх замаар байгуулах;
- Засгийн газар үлгэрчилсэн журам баталж, нийтийн өргөдлийг хүлээн авах, шийдвэрлэх нэгдсэн стандартыг тогтоох;
- Сургалт, сурталчилгаагаар дамжуулан иргэдийн цахим үйлчилгээ ашиглах мэдлэг, оролцооны идэвхийг нэмэгдүүлэх.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн талаар

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцсэн байна.

4.1. Монгол Улсын Үндсэн хуультай уялдах байдал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн ардчилал, иргэний оролцоо, нутгийн өөрөө удирдах ёсыг хангах үндсэн зарчимтай бүрэн нийцэж байна. Төсөлд тусгагдсан нийтийн өргөдлийг цахим системээр гаргах, санал өгөх боломжийг бүрдүүлэх зохицуулалтууд нь Үндсэн хуулийн дараах заалтуудтай шууд уялдаж, тэдгээрийг хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгох зорилготой:

- Үндсэн хуулийн 3 дугаар зүйл: "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ." Төсөл нь иргэдийн шууд оролцоог цахим хэлбэрээр өргөжүүлж, ардчиллын зарчмыг бэхжүүлэхэд чиглэсэн.
- Үндсэн хуулийн 16 дугаар зүйл: Иргэний үндсэн эрхүүдийн хүрээнд "шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй" (16.9), "нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй" (16.10) гэх заалтуудтай нийцэж байна. Төсөл нь эдгээр эрхийг цахим орчинд өргөтгөж, илүү хүртээмжтэй болгох замаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- Үндсэн хуулийн 62 дугаар зүйл: "Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж

шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна." Төсөл нь иргэдийн нийтийн өргөдлийг цахим хэлбэрээр гаргах механизмыг тусгаж, энэ заалтыг хэрэгжүүлэхэд таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

Хуулийн төсөл нь Үндсэн хуульд харшлахгүй бөгөөд эсрэгээрээ иргэний оролцоог өргөжүүлэх, ардчиллыг гүнзгийрүүлэхэд чиглэсэн байна. Цахим хэлбэр нэвтрүүлэх нь иргэдийн эрх тэгш байдлыг хангах Үндсэн хуулийн 1 дүгээр зүйл, 14 дүгээр зүйл зэрэгтэй мөн нийцнэ.

4.2. Бусад хуультай уялдах байдал

Хуулийн төсөл нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулгын 31 дүгээр зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилготой бөгөөд энэ хуулийн иргэдийн оролцоо, Иргэдийн Нийтийн Хурал, орон нутгийн иргэдийн өргөдлийг цахимжуулах, нутгийн өөрийн удирдлагын байгууллагын үүрэгтэй холбоотой заалтуудыг тусгасан нь хуулийн ерөнхий зарчимтай нийцнэ.

4.2.1. Бусад хуультай нийцэх байдал:

- Цахим гарын үсгийн тухай хууль (2021 оны шинэчилсэн найруулга): Төсөлд нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн саналыг "Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.3-т заасан тоон гарын үсгээр эсхүл танилт нэвтрэлтийн ДАН системээр баталгаажсан байна" гэж тусгасан нь уг хуулийн 4.1.3 заалттай шууд уялдаж, цахим баталгаажуулалтыг зохицуулна.
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль: Төсөл нь нийтийн өргөдлийн хэрэгжилтийг хангах ерөнхий, процедурын зохицуулалтыг бий болгох буюу иргэдийн мэдээлэл авах эрх, төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангана.
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль: Төсөл нь цахим систем ашиглахад хувь хүнийг тодорхойлж, хувийн мэдээллийг хамгаална.
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд иргэдийн оролцоог хангах, олон нийтийн санал, санаачилгыг бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явцад харгалзан үзэх зохицуулалттай.
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль нь иргэний хувийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн эсэхийг захиргааны журмаар шийдвэрлэхэд чиглэсэн байдаг бөгөөд өргөдөл, гомдлыг шийдвэрлэх харилцааг шууд зохицуулж ирсэн.

Хуулийн төсөл нь бусад хуультай харшлахгүй бөгөөд эсрэгээрээ цахим засаглалыг дэмжих эрх зүйн орчныг бэхжүүлнэ.

4.3. Хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд дараах шинэ журам, нэмэлт өөрчлөлтийг хийх шаардлагатай.

4.3.1. Шинээр боловсруулах журам:

- Төсөлд заасанчлан "Нийтийн өргөдлийг цахим системээр хүлээн авах үлгэрчилсэн журмыг Засгийн газар батална." Журамд цахим системийн техникийн шаардлага, тоон гарын үсэг, танилт нэвтрэлтийн систем зэрэг иргэдийн баталгаажуулалт, өргөдлийг хэлэлцэх хугацаа, ил тод байдлын механизмыг тодорхой заана.

4.3.2. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах:

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
- Иргэний бүртгэлийн тухай хууль

Эдгээр өөрчлөлтийг төрийн цахим засаглалын бодлоготой уялдуулан, иргэдийн оролцоог хангах зорилгоор боловсруулах шаардлагатай. Хуулийн төсөл батлагдсанаас хойш 3-6 сарын дотор журам, нэмэлтүүдийг боловсруулан хэрэгжүүлэх боломжтой.

---oOo---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Нэг. Хуулийн төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа

Энэхүү хуулийн нэмэлт өөрчлөлтөөр иргэдийн орон нутгийн түвшинд төрийн хэрэгт шууд болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан оролцох Үндсэн хуулиар баталгаажсан эрхийг бодитоор хэрэгжүүлэх, нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, шийдвэр гаргалтын ил тод байдал, хариуцлагыг сайжруулах зорилготой.

Нэмэлт өөрчлөлт нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар орон нутгийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудал, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар иргэд хамтын дэмжлэгт тулгуурласан нийтийн өргөдөл гаргах институтийг бий болгоход чиглэж байгаа юм. Энэ хүрээнд иргэдийн оролцоог системтэй, ил тод, хүртээмжтэй байдлаар хангах нэгдсэн цахим платформ ашиглах эрх зүйн үндсийг тогтоож, иргэдийн гаргасан санал, санаачилга нь зөвхөн зөвлөлдөх шинжтэйгээр үлдэх бус, тодорхой нөхцөлийг хангасан тохиолдолд нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр гаргалтад заавал хэлэлцэгдэх түвшинд хүргэх зохицуулалтыг тусгалаа.

Хуулийн төслөөр иргэд болон нутгийн өөрөө удирдах байгууллага хоорондын харилцааг зохицуулна. Үүнд, орон нутгийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар нийтийн өргөдөл гаргах, уг өргөдөлд хуульд заасан тооны иргэн дэмжлэг үзүүлсэн тохиолдолд Иргэдийн Нийтийн Хурал, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар заавал хэлэлцэх, хэлэлцсэн шийдвэр, үр дүнг олон нийтэд ил тод мэдээлэхтэй холбоотой харилцаа хамаарна. Зохицуулалтын хамрах хүрээ нь орон нутгийн түвшин дэх нийтийн ашиг сонирхлыг хөндсөн харилцаагаар хязгаарлагдах бөгөөд иргэний хувийн эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэх харилцааг хамаарахгүй.

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь иргэдийн цахим оролцоог бодитоор хангах зорилгоор танилт, баталгаажуулалтын системд суурилсан цахим оролцооны боломжийг бүрдүүлэх, түүнийг хэрэгжүүлэх хууль ёсны үүрэг хүлээнэ. Энэ нь биечлэн оролцох боломжгүй иргэдийн оролцооны эрхийг баталгаажуулахад чиглэсэн бөгөөд цахим оролцоог заавал хэрэгжүүлэхийг тулгах бус, тухайн орон нутгийн нөхцөл байдалд нийцүүлэн хэрэгжүүлэх уян хатан зохицуулалт болно.

Хоёр. Хуулийн төсөлд тусгасан зарчмын шинжтэй зохицуулалт

Хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгав.

Нэгдүгээрт, иргэдийн оролцоог бодитой, үр нөлөөтэй болгох зарчмыг баримталж, нийтийн өргөдлийг зөвлөмжийн шинжтэйгээр хязгаарлахгүй, харин хуульд заасан тодорхой нөхцөл хангагдсан тохиолдолд нутгийн өөрөө удирдах байгууллагаар заавал хэлэлцүүлэх нөхцлийг баталгаажуулж байна. Энэ нь иргэдийн хамтын санаачилгыг албан ёсоор хэлэлцэх, үндэслэл бүхий хариу өгөх үүргийг тодорхойлох зорилготой бөгөөд шийдвэр гаргах бүрэн эрхэд халдахгүй.

Хоёрдугаарт, ил тод, нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор нийтийн өргөдөл, санал авах үйл явц, түүнийг хэлэлцсэн дүн, гаргасан шийдвэрийг цахим системээр дамжуулан олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байдлаар мэдээлэхийг хуульчилж байна. Энэ нь орон нутгийн шийдвэр гаргалтад олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Гуравдугаарт, оролцооны найдвартай байдал, бодит байдлыг хангах зорилгоор цахим танилт, баталгаажуулалтын систем, тоон гарын үсгийг ашиглан иргэдийн оролцоог баталгаажуулах зохицуулалтыг тусгасан. Уг зохицуулалт нь давхардсан болон хуурамч оролцооноос сэргийлэх, иргэдийн оролцооны үр дүнд итгэх итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Гурав. Тухайн харилцааг хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал

Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой харилцааг Монгол Улсад шууд болон шууд бус байдлаар хэд хэдэн хууль, эрх зүйн актаар зохицуулдаг. Иргэд төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхийн үндэс нь Монгол Улсын Үндсэн хуульд туссан байдаг бөгөөд иргэн төрийн хэрэгт оролцох, төрийн байгууллага, албан тушаалтанд хандан өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй хэмээн баталгаажуулсан нь уг харилцааны суурь зарчим болж иржээ. Энэхүү зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-ийг баталж, иргэдийн гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх, шалгах, шийдвэрлэх, хариу өгөх хугацаа, хэлбэр, төрийн байгууллага, албан тушаалтны үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулсан байдаг. Уг хууль нь иргэний хувийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн эсэхийг захиргааны журмаар шийдвэрлэхэд чиглэсэн байдаг бөгөөд өргөдөл, гомдлыг шийдвэрлэх харилцааг шууд зохицуулж ирсэн гол хууль юм.

Түүнчлэн, Захиргааны ерөнхий хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь иргэний өргөдөл, гомдлын дагуу гарсан захиргааны шийдвэрийн хууль ёс, үндэслэлийг хянах, эрхээ хамгаалуулах

механизмыг бүрдүүлсэн байдаг бол Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль зэрэг нь мэдээлэл авах, цахимаар өргөдөл гаргах, хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах замаар энэхүү харилцааг шууд бус байдлаар зохицуулдаг.

Мөн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар нутгийн өөрөө удирдах байгууллагад иргэдийн өргөдөл, санал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, холбогдох байгууллагад уламжлах чиг үүргийг тодорхойлсноор орон нутгийн түвшинд эрх зүйн орчныг бүрдүүлсэн байдаг.

Гэвч эдгээр зохицуулалт нь хувь хүний эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэж байдаг буюу нийтийн ашиг сонирхлыг хөндсөн, иргэдийн хамтын санаачилгад тулгуурласан нийтийн өргөдлийг бие даасан институцийн түвшинд зохицуулж чадахгүй юм.

Харин Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлээр иргэд нийтийн өргөдөл гаргах боломжтой хэдий ч энэхүү эрх нь зөвхөн Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог ханган нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар иргэдээс ирүүлсэн өргөдлийг шийдвэрлэхэд чиглэдэг байна.

Дөрөв. Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Хууль санаачлагчдын зүгээс энэхүү хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулах зорилгоор хуульч, судлаач, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл орсон ажлын хэсгийг байгуулан ажилласан.

Хуулийн төслийн хүрээнд орон нутгийн төрийн байгууллагуудаас гарч буй шийдвэрүүдэд иргэдийн оролцооны түвшинг үнэлэх зорилгоор орон нутгийн хөгжлийн санд иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдол, хүсэлтийн тоо, тэдгээрийн хэрэгжилт, шийдвэрлэсэн хувь хэмжээ, үр дүнг тоон болон чанарын мэдээллийн шинжилгээ, бусад улс орны ижил төстэй платформууд, тэдгээрийн хэрэгжилт, тоон мэдээлэл болон онцлох жишээнүүдийн харьцуулалт бүхий судалгаа, лавлагаа, мэдээллийг Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгээр гүйцэтгүүлэв.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажиллагааг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулсан. Цахим хэлэлцүүлэг 2025 оны 12 дугаар сарын 23-нд d.parliament.mn платформд байршиж иргэдийн саналыг авч эхэлсэн бол биечилсэн хэлэлцүүлгүүдийг 2026 оны 1 дүгээр сарын 21-нд Төрийн ордны Үндсэн хууль танхимд, мөн 2026 оны 01-р сарын 23-ны өдөр Баянгол дүүргийн ИТХ, Иргэний танхим зохион байгуулав.

Танхимын хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл, хараат бус судлаачид, иргэд, Хэнтий, Сэлэнгэ, Багануур, Дархан, Сүхбаатар дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид, төрийн захиргааны байгууллагын ажилтнууд оролцсон. Цахим хэлбэрээр 5 санал, танхимын хэлэлцүүлгийн явцад нийт 17 санал олон нийтээс ирсэнийг хуулийн төсөлд тусгав.

Хуулийн төслийг хэлэлцүүлэх явцад иргэд, байгууллагуудаас цахим оролцоог дэмжих, ил тод байдлыг хангах чиглэлээр олон санал ирүүлсэн. Үүнд, өргөдөл гомдлыг сум, дүүргийн хэмжээнд нэгдсэн системд оруулах, хурлын тов, шийдвэрийг цахимд бүрэн байршуулах, байгаль орчны асуудлаар зураг, байршил хавсаргаж хэлэлцүүлэх боломжийг хуульчлах хүсэлтүүд багтсан байна. Харин цөөн хүний оролцоотой шийдвэр гаргах, хуурамч лобби үүсэх, үргүй зардал гарах эрсдэлээс сэргийлж, нийтийн өргөдлийг цахимд байршуулах хугацааг ажлын 30 хоног болгох, хэлэлцэх иргэдийн дэмжлэгийн хувь хэмжээг 3% ба 5% байгааг 5% ба 8% болгон өсгөх шаардлагыг тавьжээ.

Орон нутгийн хурлын байгууллагуудын зүгээс Иргэдийн Нийтийн Хурлын даргын бүрэн эрхийг сонгуулийн хугацаатай уялдуулах, хурал зарлах зохицуулалтыг нарийвчлах, баг хорооны ИНХ-ын архивыг дээд шатны хурлын ажлын алба эсвэл төрийн архивт шилжүүлэх санал өгсөн байна. Мөн хурлын даргын захирамжийн эрх хэмжээг өргөтгөх, шагнал уламжлах эрхийг нэмэх, хууль зөрчсөн шийдвэрийг дээд шатны Хурлын дарга хүчингүй болгодог байх зэрэг захиргааны өөрчлөлтүүдийг дэвшүүлжээ. Нийслэлийн дүүргүүдээс Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүд төслийг дэмжсэн бол Налайх, Баянзүрх дүүрэг тусгайлсан саналгүй гэсэн ба Баянгол дүүрэг саналуудаа нэгтгэн дараа хүргүүлэхээ мэдэгдсэн байна.

Мөн УИХ-ын Инновац, цахим бодлогын байнгын хорооноос “Хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлгийг 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулж хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог бодитой, үр нөлөөтэй болгоход цахим системийн үүрэг, уг системийн эрх зүйн зохицуулалт, техникийн шийдэл, сурталчилгаа, судалгаанд суурилсан сайжруулалтууд зэрэг цаашид хийх ажлуудын талаар байр сууриа илэрхийлсэн.

Хэлэлцүүлгийн үеэр УИХ-ын Тамгын газрын Хуулийн газар, Мэдээллийн технологийн газраас нийтийн өргөдлийн цахим системийн өнөөгийн байдал, хэрэгжилтийн статистик мэдээлэл, тулгамдаж буй асуудлын талаар танилцуулга хийсэн. Мөн иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, судлаачид хууль тогтоох үйл ажиллагаанд олон нийтийг оролцуулах одоогийн хэлбэр, ил тод байдал, санал авах хугацаа, хэлэлцүүлгийн арга хэлбэрийг сайжруулах шаардлагын талаар саналаа хэлсэн. Түүнчлэн нийтийн өргөдлийн цахим системийг ашигласан иргэдийн төлөөлөл өөрсдийн туршлага, тулгарсан хүндрэл, санал дэмжлэг цуглуулах явц дахь саад бэрхшээлийг хуваалцаж, системийн хүртээмж,

хэрэглээний хялбар байдлыг сайжруулах, мэдээлэл түгээх ажлыг эрчимжүүлэх шаардлагатайг тэмдэглэсэн.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооноос “Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах нь” сэдэвт хэлэлцүүлгийг 2025 оны 12 дугаар сарын 02-нд зохион байгуулж, нийтийн өргөдлийг цахим системээр дамжуулан хүлээн авах, нийтлэх, санал авах ажиллагааг зохицуулах журмын төслийг олон талын оролцоотойгоор хэлэлцсэн.

Хэлэлцүүлгийн үр дүнд, журмын төсөлд нийтийн өргөдөлд тавигдах шаардлага, хугацаа, ил тод байдлын зохицуулалтыг тодорхой болгох, цахим системийн хүртээмж, хэрэглээний хялбар байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд саадгүй ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, эргэх холбоог сайжруулах заалтуудыг тусгаж нийтийн өргөдлийн цахим системийг бодит үр нөлөөтэй хэрэгсэл болгож чадах агуулгуудыг шингээх шаардлагатайг онцолсон болно.

Тав. Гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлт

Орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог хангах, шийдвэр гаргах үйл явцад татан оролцуулах платформыг хөгжүүлэх ажлын хүрээнд жишиг платформыг санаачлан хэрэгжүүлж буй гадаадын улс орнуудын туршлагыг судлах зорилгоор “Орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог хангах, шийдвэр гаргах үйл явцад татан оролцуулах платформ” харьцуулсан судалгааг Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгээр гүйцэтгүүлсэн болно.

Судалгаанд хамрагдсан Бразилын “Brasil Participativo”, Энэтхэгийн “MyGov”, Исландын Рейкьявикийн “Better Reykjavík” болон Испанийн Барселона хотын “Decidim.barcelona” платформууд нь зорилго, оролцооны хэлбэрийн хувьд харилцан адилгүй боловч нийтлэгээр иргэдийн шууд оролцоог институцийн түвшинд нэмэгдүүлэх, бодлого боловсруулах, төсөв хэлэлцэх, хот төлөвлөлт, салбарын реформ зэрэгт иргэдийн санал санаачилгыг системтэй шингээхэд чиглэсэн байна.

Үндэсний түвшний платформууд болох Бразил болон Энэтхэгийн системүүд нь хөгжлийн төлөвлөгөө, салбарын бодлогын төслүүдэд (жишээ нь, “Үндэсний хөгжлийн төлөвлөгөө 2024-2027”, боловсролын шинэ бодлого, татварын шинэчлэл) иргэдийн саналыг авах өргөн цар хүрээтэй цахимжсан зөвлөлдөх, санал авах тогтолцоог бүрдүүлжээ. Харин хотын түвшний платформууд болох Рейкьявикийн “Better Reykjavík” болон Барселонагийн “Decidim.barcelona” нь орон нутгийн өдөр тутмын шийдвэр гаргалт, төсөв, орчны төлөвлөлт, нийгмийн үйлчилгээ, соёлын бодлого зэрэгт иргэдийн оролцоог уялдуулсан цахим ардчиллын систем болж төлөвшжээ.

Оролцооны хэлбэрийн хувьд Бразил, Исланд, Барселонагийн платформууд нь цахимд суурилсан санал асуулга, хэлэлцүүлэг, иргэний санаачилга, төсвийн хэлэлцүүлгүүдийг танхимын уулзалт, хөршийн хурал, нийтийн сонсгол зэрэг биеэр оролцох хэлбэрүүдтэй уялдуулан шат дараалсан, ил тод оролцооны процесс бүрдүүлсэн байна. Харин Энэтхэгийн “MyGov” платформ нь голчлон цахим оролцоонд тулгуурлаж, тодорхой модулиараа сайн дурын оффлайн үйл ажиллагаатай холбогдсон байгаагаараа онцлогтой.

Иргэдийн цахим оролцоог хэрэгжүүлэх институт, засаглалын зохион байгуулалтын хувьд Бразил Улсад Ерөнхийлөгчийн Тамгын газар, Энэтхэг Улсад Ерөнхий сайдын ажлын алба болон Үндэсний мэдээллийн төв зэрэг төв байгууллагууд үндэсний түвшний платформыг санаачлан хөгжүүлж, бүх яам, агентлаг, муж улсыг нэгдсэн дэд бүтцэд холбосон байна. Харин Испанийн Барселона хотын “Decidim.barcelona” платформыг хотын захиргаа удирдан зохион байгуулж, “Decidim Association” нь нээлттэй эхийн хөгжүүлэлт, олон улсын хамтын ажиллагааны сүлжээг хариуцан, орон нутагт төвтэй, бусад улс, хотод нэвтрүүлэх боломжтой загварыг хөгжүүлжээ. Харин Исланд Улсын Рейкьявик хотын “Better Reykjavík” платформ нь “Citizens Foundation” хэмээх иргэний нийгмийн байгууллага болон хотын захиргааны түншлэлийн үндсэн дээр хөгжсөнөөрөө онцлогтой. Үүнээс үзэхэд иргэдийн оролцооны платформыг тогтвортой хэрэгжүүлэх суурь нөхцөл нь улс төрийн манлайлал, албан ёсны бодлого, эрх зүйн дэмжлэг болохын зэрэгцээ уг платформыг байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, төлөвлөлтийн мөчлөгтэй институцийн хувьд уялдуулах, онлайн болон оффлайн хэлбэрийн оролцоог зөвшөөрөх шаардлагатай болохыг харуулж байна.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Нэг. Нийтлэг тайлбар

Энэхүү дэлгэрэнгүй танилцуулгыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 33.3, 33.4-т заасны дагуу хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр багцлан боловсруулсан бөгөөд дараах агуулгыг хамруулсан болно. Үүнд: нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрчлөн найруулах болсон үндэслэл, шаардлага; зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, түүнийг хэрхэн ойлгох тухай тайлбар; гадаад улсын хууль тогтоомж, практик туршлагатай харьцуулсан тайлбар, дүгнэлт; нэр томьёо, ухагдахууны тайлбар.

Хуулийн төслийн зорилго нь тухайн нэгжид байнга оршин суугаа, сонгуулийн эрх бүхий иргэдийн орон нутгийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар хамтын санаачилга гаргах эрхийг бодитой хэрэгжүүлэх, энэхүү санаачилгыг нийтийн өргөдөл хэлбэрээр хуульчлах, тодорхой босго хангасан тохиолдолд нутгийн өөрөө удирдах байгууллагаар заавал хэлэлцүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд оршино.

Хуулийн төслийн үзэл баримтлал, товч танилцуулгад дурдсанаар Монгол Улсын Үндсэн хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн өнөөгийн зохицуулалт нь иргэдийн оролцооны ерөнхий суурийг тогтоосон боловч орон нутгийн түвшинд нийтийн ашиг сонирхлыг хөндсөн хамтын санаачилгыг системтэй, хэмжигдэхүйц, цахим баталгаажуулалттай хэлбэрээр шийдвэр гаргалтад хүргэх бодит механизм хангалтгүй хэвээр байна. Иймээс энэхүү төслөөр 31 дүгээр зүйлийг шинэчлэн найруулж, нийтийн өргөдөл, цахим дэмжлэг, дэмжлэгийн босго, заавал хэлэлцэх үүрэг, тоон гарын үсгийн баталгаажуулалт, зөвлөлдөх санал асуулгын уялдаа зэргийг тусгасан болно.

Хоёр. Төслийн 1 дүгээр зүйлийн тайлбар

2.1. Төслийн 1 дүгээр зүйлээр 31 дүгээр зүйлийг бүхэлд нь өөрчлөн найруулж буйтай холбоотой нийтлэг тайлбар

2.1.1. Өөрчлөн найруулах болсон үндэслэл, шаардлага

Одоо мөрдөгдөж байгаа хуулийн 31 дүгээр зүйл нь нутгийн өөрийн удирдлага дахь иргэний оролцооны нийтлэг агуулгыг тусгасан боловч иргэдийн хамтын санаачилгыг заавал хэлэлцэх институцийн түвшинд хүргэх тодорхой процедур, шалгуур, үр дагаврыг бүрэн тогтоогоогүй байна. Үүний улмаас иргэдийн санал, хүсэлт, санаачилга нь олон тохиолдолд зөвлөмжийн шинжтэй үлдэж, төлөөллийн байгууллагын хэлэлцэх асуудалд албан ёсоор орохгүй байх, эргэх холбоо сул байх, оролцооны үр нөлөө бага байх нөхцөл бүрдэж ирсэн.

Хуулийн төслийн үзэл баримтлалд орон нутгийн түвшинд иргэдийн оролцооны одоогийн эрх зүйн боломж “цаасан дээрх амьгүй заалт” болох эрсдэлтэй байгааг онцолж, үүнийг цахим платформ, баталгаажуулалт, босго, албан ёсны хэлэлцүүлгийн механизмтай уялдуулан шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн. Товч танилцуулгад мөн иргэдийн нийтийн ашиг сонирхлыг хөндсөн хамтын санаачилгыг бие даасан институцийн түвшинд зохицуулах хэрэгцээ байгааг тайлбарласан.

2.1.2. Зохицуулалтын агуулгыг хэрхэн ойлгох тухай

31 дүгээр зүйлийг бүхэлд нь шинэчлэн найруулж байгаа нь өмнөх ерөнхий зохицуулалтыг халж, орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог нийтийн өргөдөлд суурилсан, цахим орчинд хэрэгжих боломжтой, тодорхой босготой, албан ёсны хэлэлцүүлэгт хүргэдэг тогтолцоо болгон өөрчилж байгааг илэрхийлнэ.

2.1.3. Гадаад улсын зохицуулалттай харьцуулсан тайлбар, дүгнэлт

Бразилын “Brasil Participativo”, Энэтхэгийн “MyGov”, Исландын “Better Reykjavik”, Испанийн Барселона хотын “Decidim.barcelona” зэрэг платформуудын нийтлэг шинж нь иргэдийн оролцоог зөвхөн санал авах төдий бус, бодлого, төсөв, орон нутгийн шийдвэр гаргалтын институцийн процесст шингээхэд оршдог. Энэхүү төслийн 31 дүгээр зүйлийн шинэчилсэн найруулга нь уг олон улсын чиг хандлагыг Монгол Улсын нутгийн удирдлагын тогтолцоонд тохируулан нутагшуулах зорилготой.

2.1.4. Нэр томьёо, ухагдахууны тайлбар

“Нутгийн өөрийн удирдлага дахь иргэний оролцоо” гэж тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлаар иргэд санал гаргах, санаачилга дэвшүүлэх, хэлэлцүүлэх, шийдвэр гаргалтад нөлөөлөх эрх зүйн боломж, түүнийг хэрэгжүүлэх хэлбэр, механизмыг ойлгоно.

2.2. Төслийн 31.1 дэх хэсгийн тайлбар

Төслийн зохицуулалт

Тухайн нэгжид байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэд сайн дураараа хамтарч тухайн нэгжийнхээ эдийн засаг, нийгмийн тулгамдсан, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар нэг удаагийн, эсхүл хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахыг санаачлах эрхтэй бөгөөд энэхүү эрхээ нийтийн өргөдөл гаргах замаар хэрэгжүүлэх, нийтийн өргөдлийг цахим системээр гаргаж, хүлээн авч болохоор тусгажээ.

2.2.1. Өөрчлөн найруулах болсон үндэслэл, шаардлага

Үндсэн хуулиар иргэн төрийн хэрэгт шууд болон төлөөллийн байгууллагаараа уламжлан оролцох эрхтэй боловч орон нутгийн түвшинд нийтийн шинжтэй асуудлаар хамтын санаачилга гаргах тусгай, шууд үйлчлэх механизм хангалтгүй байна. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай

хууль нь гол төлөв иргэний хувийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах захиргааны журмыг тогтоодог бөгөөд нийтийн ашиг сонирхлыг хөндсөн хамтын өргөдлийг тусгайлан зохицуулдаггүй.

Хуулийн төслийн үзэл баримтлалд орон нутгийн асуудлаар иргэд нийтийн өргөдөл гаргах эрх зүйн орчныг бий болгох шаардлагыг онцолж, иргэд оршин суугаа нэгжийнхээ тулгамдсан асуудлыг хамгийн сайн мэддэг тул тэдний санаачилга нь бодлогыг бодит хэрэгцээнд нийцүүлэх ач холбогдолтой гэж дүгнэсэн.

2.2.2. Зохицуулалтын агуулгыг хэрхэн ойлгох тухай

Энэ хэсгээр нийтийн өргөдөл гаргах эрх бүхий этгээд, өргөдлийн хамрах асуудал, хэрэгжүүлэх хэлбэрийг нэг мөр тодорхойлж байна. Үүнд:

- эрх бүхий этгээд нь тухайн нэгжид байнга оршин суугаа, сонгуулийн эрх бүхий иргэн байна;
- асуудлын хүрээ нь тухайн нэгжийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал байна;
- санаачилгын эрхийг нийтийн өргөдөл хэлбэрээр хэрэгжүүлнэ;
- нийтийн өргөдлийг цахим системээр гаргаж, хүлээн авч болно.

“Нэг удаагийн шийдвэр” гэж тодорхой нэг асуудлаар тухайн удаад гаргах шийдвэрийг, “хэм хэмжээ тогтоосон шийдвэр” гэж нийтлэг дагаж мөрдөх шинжтэй журам, тогтоол, чиглэл бүхий шийдвэрийг ойлгоно.

2.2.3. Гадаад улсын зохицуулалттай харьцуулсан тайлбар, дүгнэлт

Исландын “Better Reykjavík”, Барселонагийн “Decidim.barcelona” зэрэг платформуудад иргэд орон нутгийн амьдралд хамаарах тодорхой асуудлаар санал, санаачилга дэвшүүлж, цахим хэлбэрээр дэмжлэг цуглуулан хотын удирдлагын түвшинд хэлэлцүүлэх боломжтой байдаг. Энэтхэгийн “MyGov”, Бразилын “Brasil Participativo” платформууд ч мөн иргэдийн санаачилгыг бодлого, төлөвлөгөөнд шингээхэд чиглэсэн. Төслийн энэ хэсэг нь уг туршлагын үндсэн логик болох иргэдийн санаачилга, цахим оролцоо, институцийн хэлэлцүүлэг гэсэн гурвалсан хандлагатай нийцэж байна.

2.2.4. Нэр томьёо, ухагдахууны тайлбар

“Нийтийн өргөдөл” гэж нэг иргэний хувийн асуудлаарх өргөдлөөс ялгаатай, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар олон иргэний хамтын санаачилгыг илэрхийлсэн өргөдлийг ойлгоно. “Эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудал” гэж тухайн орон нутгийн хөгжлийн бодлого, төсөв, дэд бүтэц, нийтийн үйлчилгээ, орчны зохион байгуулалт, нийгмийн үйлчилгээ, хүртээмж зэрэг олон нийтэд нийтлэг нөлөө үзүүлэх асуудлыг ойлгоно. “Нийтийн ашиг сонирхол” гэж нэг этгээдийн хувийн ашиг сонирхлоос ялгаатай, тухайн нутаг дэвсгэрийн нийт иргэн, оршин суугчид, эсхүл тэдний тодорхой бүлэгт хамаарах нийтлэг ашиг, хэрэгцээг хэлнэ.

2.3. Төслийн 31.2 дахь хэсгийн тайлбар

Төслийн зохицуулалт

Нийтийн өргөдлийг Иргэдийн Нийтийн Хурал болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлын хүрээнд гаргана.

2.3.1. Өөрчлөн найруулах болсон үндэслэл, шаардлага

Иргэдийн оролцооны эрхийг өргөжүүлэхийн зэрэгцээ тухайн оролцоо нь эрх хэмжээний хувьд хэрэгжих боломжтой, бодит үр дагавартай байх шаардлагатай. Хэрэв нийтийн өргөдлийн хамрах хүрээг тодорхой заагаагүй бол өөр байгууллагын бүрэн эрхэд хамаарах, хууль зүйн хувьд шийдвэрлэх боломжгүй, эсхүл улсын төв байгууллагын эрх хэмжээний асуудлаар өргөдөл гаргах замаар төөрөгдөл үүсэх эрсдэлтэй.

Үзэл баримтлалд энэ асуудлыг тусгайлан хөндөж, орон нутгийн асуудлыг УИХ-ын нийтийн өргөдлийн платформд гаргах нь эрх зүйн хувьд оновчтой бус байгааг дурдсан. Иймд нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхэд нийцүүлэн орон нутгийн түвшний өргөдлийн механизмыг тусгаарлан тогтоох шаардлагатай гэж үзсэн.

2.3.2. Зохицуулалтын агуулгыг хэрхэн ойлгох тухай

Энэ хэсэг нь нийтийн өргөдөл дурын асуудлаар бус, зөвхөн тухайн шатны ИНХ, ИТХ-аас хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэлэлцэж, шийдвэрлэж болох асуудлын талаар байна гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл, нийтийн өргөдөл нь эрх хэмжээний гаднах улс төрийн мэдэгдэл, төв байгууллагад хамаарах асуудал, эсхүл шүүх, захиргааны өөр байгууллагын шийдвэрлэх асуудлыг хамрахгүй.

2.3.3. Гадаад улсын зохицуулалттай харьцуулсан тайлбар, дүгнэлт

Олон улсын платформуудад иргэдийн санал, санаачилгыг ангилан ялгаж, тухайн байгууллагын эрх хэмжээний хүрээнд хамаарах эсэхийг урьдчилан шалгах нь нийтлэг байдаг. Энэ нь платформыг дурын шаардлага цуглуулах талбар бус, эрх зүйн үр дагавартай оролцооны хэрэгсэл болгодог. Иймд төслийн энэ зохицуулалт нь олон улсын сайн туршлагатай нийцэж байна.

2.3.4. Нэр томьёо, ухагдахууны тайлбар

“Бүрэн эрхэд хамаарах асуудал” гэж тухайн шатны ИНХ, ИТХ хуульд заасан чиг үүргийн дагуу хэлэлцэж, шийдвэрлэж болох асуудлыг хэлнэ.

2.4. Төслийн 31.3 дахь хэсгийн тайлбар

Төслийн зохицуулалт

Нутгийн өөрөө удирдах байгууллага дараах үндэслэлээр нийтийн өргөдлийг хүлээн авахгүй байхаар заасан. Үүнд: 31.3.1. 31.2-т заасан асуудлын хүрээнд хамаарахгүй; 31.3.2. улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний аюулгүй байдалд харшилсан; 31.3.3. бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироох, ялгаварлан гадуурхахыг уриалсан; 31.3.4. өргөдөлд дурдсан асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа; 31.3.5. хувийн асуудлаар гаргасан.

2.4.1. Өөрчлөн найруулах болсон үндэслэл, шаардлага

Нийтийн өргөдлийн механизм нь нээлттэй, хүртээмжтэй байх ёстой боловч үүнийг Үндсэн хуулийн суурь үнэт зүйл, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, шүүхийн шийдвэрийн тогтвортой байдалтай зөрчилдөх хэлбэрээр ашиглахыг хориглох шаардлагатай. Иймд хүлээн авахгүй байх үндэслэлийг хуульд тодорхой тусгах нь эрх зүйн тодорхой байдал, урьдчилан таамаглах боломжийг хангана.

2.4.2. Зохицуулалтын агуулгыг хэрхэн ойлгох тухай

Энэ хэсэг нь иргэдийн өргөдөл гаргах эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлаж байгаа бус, харин нийтийн өргөдлийн институтыг хууль ёсны зорилгоор ашиглах хүрээг тогтоож байгаа шүүлтүүрийн зохицуулалт юм. Ингэснээр өргөдлийг хүлээн авах эсэхийг дур мэдэн бус, хуульд заасан объектив шалгуураар шийдвэрлэнэ.

31.3.1 нь эрх хэмжээний шалгуурыг, 31.3.2 нь Үндсэн хуулийн байгууллын суурь үнэт зүйлийг, 31.3.3 нь хүний эрхийг, 31.3.4 нь шүүхийн шийдвэрийн эцэслэн шийдвэрлэх зарчмыг, 31.3.5 нь нийтийн болон хувийн өргөдлийн ялгааг хамгаалж байна.

2.4.3. Гадаад улсын зохицуулалттай харьцуулсан тайлбар, дүгнэлт

Оролцооны платформ бүхий улс орнуудын нийтлэг жишиг нь үзэн ядалт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, эрх хэмжээний гаднах шаардлага, эсхүл шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн асуудлыг нийтийн санаачилга, өргөдлийн платформоор дахин хэлэлцүүлэхгүй байх зарчим юм. Төслийн энэ хэсэг нь ийм нийтлэг хамгаалалтын стандартыг Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн тусгаж байна.

2.4.4. Нэр томьёо, ухагдахууны тайлбар

“Хүлээн авахгүй байх үндэслэл” гэж өргөдлийг агуулгын хувьд урьдчилан шалгаж, хуульд нийцэхгүй тохиолдолд албан ёсоор бүртгэхгүй байх нөхцөлийг ойлгоно. “Хувийн асуудал” гэж нэг иргэний хувийн эрх, үүрэг, эрх зүйн байдал, ашиг сонирхол, маргаан, үйлчилгээтэй холбоотой, нийтийн ашиг сонирхлын шинжгүй асуудлыг хэлнэ.

2.5. Төслийн 31.4 дэх хэсгийн тайлбар

Төслийн зохицуулалт

Нийтийн өргөдлийг цахим системд 30 хоногийн хугацаатай байршуулах бөгөөд уг өргөдлийг нийслэл, дүүрэг, хороонд байнга оршин суугаа, Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэдийн 3 хувь ба түүнээс дээш; аймаг, сум, багт байнга оршин суугаа, Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэдийн 5 хувь ба түүнээс дээш тооны иргэн дэмжсэн бол нутгийн өөрөө удирдах байгууллага хэлэлцэх үүрэгтэй.

2.5.1. Өөрчлөн найруулах болсон үндэслэл, шаардлага

Иргэдийн санаачилга бүрийг дэмжлэгийн шалгуургүйгээр шууд хэлэлцэх зохицуулалт хийвэл төлөөллийн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд хэт ачаалал үүсэх эрсдэлтэй. Нөгөө талаас олон нийтийн бодитой дэмжлэг авсан асуудлыг хэлэлцэхгүй орхих нь иргэдийн оролцооны утга агуулгыг сулруулна. Иймээс тодорхой хугацаа, дэмжлэгийн босго, албан ёсны хэлэлцэх үүрэг гэсэн гурван нөхцөлийг хамтад нь тогтоох шаардлагатай.

Үзэл баримтлалд нийтийн өргөдөл хүлээн авах, нийтлэх, санал авах, явцыг хянах цахим платформ, түүнтэй уялдсан албан ёсны шийдвэр гаргах механизм шаардлагатайг онцолсон. Товч танилцуулгад мөн тодорхой нөхцөл хангасан өргөдлийг ИНХ, ИТХ-аар заавал хэлэлцүүлэх нь төслийн гол зарчим болохыг тэмдэглэсэн.

2.5.2. Зохицуулалтын агуулгыг хэрхэн ойлгох тухай

Энэ хэсэг нь нийтийн өргөдлийн процедурын үндсэн цөм болно. Үүнд:

- нийтийн өргөдөл цахим системд 30 хоног байрлана;
- энэ хугацаанд холбогдох нутаг дэвсгэрийн байнгын оршин суугч, 18 насанд хүрсэн иргэд дэмжлэг үзүүлнэ;
- нийслэл, дүүрэг, хороонд 3 хувь; аймаг, сум, багт 5 хувь-ийн босго хангавал;
- нутгийн өөрөө удирдах байгууллага уг асуудлыг заавал хэлэлцэнэ.

“Хэлэлцэх үүрэгтэй” гэдэг нь тухайн байгууллага уг өргөдлийг албан ёсоор хуралдааны хэлэлцэх асуудалд оруулж авч үзэхийг хэлэхээс бус, өргөдөлд заасан агуулгаар заавал эерэг шийдвэр гаргана гэсэн утгатай биш юм.

2.5.3. Гадаад улсын зохицуулалттай харьцуулсан тайлбар, дүгнэлт

Олон улсын жишгээр иргэдийн санаачилгыг албан ёсны хэлэлцүүлэгт оруулахын тулд тодорхой тооны дэмжлэг, гарын үсэг, оролцооны босго тогтоодог. Исланд, Испани, Бразилын платформуудын практикт санал, дэмжлэгийн түвшин нь тухайн санаачилга институцийн шатанд шилжих шалгуур болж ажилладаг. Төслийн 3 хувь, 5 хувийн босго нь гадаадын аль нэг улсаас шууд хуулбарлаагүй боловч олон нийтийн жинтэй

дэмжлэгийг ялгаж авах олон улсын нийтлэг зарчимд нийцсэн, Монгол Улсын хот-хөдөөгийн хүн амын бүтэц, нягтралыг харгалзан тогтоосон дотоод шийдэл юм.

2.5.4. Нэр томьёо, ухагдахууны тайлбар

“Дэмжлэгийн босго” гэж нийтийн өргөдлийг албан ёсоор хэлэлцүүлэхэд шаардлагатай иргэдийн хамгийн доод тоон шалгуурыг хэлнэ. “Цахим системд байршуулах” гэж өргөдлийг нийтэд ил тод, тодорхой хугацаанд нээлттэй байршуулж, дэмжлэг авах боломжтой болгох ажиллагааг ойлгоно.

2.6. Төслийн 31.5 дахь хэсгийн тайлбар

Төслийн зохицуулалт

Нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.3-т заасан тоон гарын үсгээр баталгаажсан байна.

2.6.1. Өөрчлөн найруулах болсон үндэслэл, шаардлага

Цахим оролцооны механизмын найдвартай байдлыг хангахгүй бол нэг этгээд олон дахин дэмжлэг үзүүлэх, хуурамч бүртгэл ашиглах, дэмжлэгийн бодит тоог тогтоох боломжгүй болох эрсдэл үүснэ. Иймээс дэмжлэгийн үнэн зөв, давхардалгүй байдлыг хууль зүйн хувьд баталгаажуулах шаардлагатай.

Товч танилцуулгад оролцооны найдвартай байдал, бодит байдлыг хангах зорилгоор цахим танилт, баталгаажуулалтын систем, тоон гарын үсэг ашиглах нь төслийн үндсэн зарчмын нэг гэж тайлбарласан.

2.6.2. Зохицуулалтын агуулгыг хэрхэн ойлгох тухай

Энэ хэсгээр нийтийн өргөдлийг дэмжиж буй санал нь энгийн тэмдэглэгээ, бүртгэл бус, хуульд заасан баталгаажсан тоон гарын үсгээр нотлогдсон байхыг шаардсан. Ингэснээр:

- санал өгсөн этгээдийг зөв тодорхойлох;
- давхардсан дэмжлэгээс сэргийлэх;
- дэмжлэгийн тоо бодит эсэхийг шалгах;
- цахим оролцооны системд итгэх итгэлийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэнэ.

2.6.3. Гадаад улсын зохицуулалттай харьцуулсан тайлбар, дүгнэлт

Гадаадын оролцооны платформуудад төрийн цахим танилт, хэрэглэгчийн баталгаажуулалт, дижитал бүртгэл зэрэг янз бүрийн арга ашигладаг. Монгол Улсын нөхцөлд үүнийг Цахим гарын үсгийн тухай хуульд нийцүүлэн тоон гарын үсэг-ээр баталгаажуулах нь үндэсний эрх зүйн орчин, цахим засаглалын бодлоготой нийцсэн шийдэл юм.

2.6.4. Нэр томьёо, ухагдахууны тайлбар

“Тоон гарын үсэг” гэж Цахим гарын үсгийн тухай хуульд заасан, цахим өгөгдөлд хавсаргасан, гарын үсэг зурсан этгээдийг таних болон тухайн өгөгдлийн бүрэн бүтэн байдлыг баталгаажуулах зориулалттай цахим гарын үсгийн төрлийг ойлгоно.

2.7. Төслийн 31.6 дахь хэсгийн тайлбар

Төслийн зохицуулалт

Нийтийн өргөдлийг цахим системээр хүлээн авах үлгэрчилсэн журмыг Засгийн газар батална.

2.7.1. Өөрчлөн найруулах болсон үндэслэл, шаардлага

Хуулийн түвшинд зөвхөн үндсэн эрх, үүрэг, нөхцөл, шалгуурыг тогтоох бөгөөд өргөдөл гаргах, бүртгэх, байршуулах, дэмжлэг баталгаажуулах, босго тооцох, хэлэлцэх шатанд шилжүүлэх, шийдвэрийн талаар мэдээлэх зэрэг нарийвчилсан ажиллагааг журамд тусгах шаардлагатай. Үгүй бол нэгж бүр өөр өөр хэлбэрээр хэрэгжүүлж, эрх зүйн тодорхой бус байдал үүсэх эрсдэлтэй.

2.7.2. Зохицуулалтын агуулгыг хэрхэн ойлгох тухай

Энэ хэсгээр Засгийн газарт нийтийн өргөдлийн цахим системийн ажиллагааны нийтлэг стандартыг тогтоох эрх олгож байна. Үлгэрчилсэн журамд дараах асуудлыг багтаах боломжтой. Үүнд: өргөдөл гаргах шаардлага, хэлбэр; цахим системийн техникийн шаардлага; баталгаажуулалтын горим; дэмжлэгийн тооцоолол; ил тод байдал, мэдээллийн хүртээмж; хэлэлцэх шатанд шилжүүлэх, шийдвэрийн тухай мэдээлэх журам.

2.7.3. Гадаад улсын зохицуулалттай харьцуулсан тайлбар, дүгнэлт

Гадаадын оролцооны платформууд зөвхөн хуульд бус, нарийвчилсан ажиллагааны дүрэм, техникийн стандарт, хэрэглээний заавар, ил тод байдлын шаардлагад тулгуурлан тогтвортой хэрэгждэг. Иймээс энэ хэсэг нь олон улсын сайн туршлагын дагуу хууль ба дэд журмын уялдааг хангаж байна.

2.7.4. Нэр томьёо, ухагдахууны тайлбар

“Үлгэрчилсэн журам” гэж улс даяар нийтлэг мөрдөх суурь шаардлага, ажиллагааны стандартыг тогтоосон журмыг хэлнэ.

2.8. Төслийн 31.7 дахь хэсгийн тайлбар

Төслийн зохицуулалт: Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шаардлагатай гэж үзвэл нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар гаргах шийдвэрийн талаар хуульд заасны дагуу зөвлөлдөх санал асуулга явуулж болно.

2.8.1. Өөрчлөн найруулах болсон үндэслэл, шаардлага

Нийтийн өргөдөл нь иргэдийн санаачилгыг эхлүүлэх, тодорхой босго хангасан асуудлыг хэлэлцүүлэх механизм бол зөвлөлдөх санал асуулга нь тодорхой асуудлаар олон нийтийн байр суурийг урьдчилан тандах, нягтлах оролцооны хэлбэр юм. Иймд нийтийн өргөдөл болон зөвлөлдөх санал асуулгыг хооронд нь өрсөлдүүлэх бус, харилцан нөхөх байдлаар хадгалах шаардлагатай.

2.8.2. Зохицуулалтын агуулгыг хэрхэн ойлгох тухай

Энэ хэсгээр ИТХ-д тухайн нутаг дэвсгэрийн тулгамдсан асуудлаар шийдвэр гаргахын өмнө иргэдийн санал бодлыг зөвлөлдөх хэлбэрээр авах боломжийг хадгалж байна. Энэ нь нийтийн өргөдлөөс өөр институт бөгөөд олон нийтийн байр суурийг илүү өргөн хүрээнд сонсох зорилготой.

2.8.3. Гадаад улсын зохицуулалттай харьцуулсан тайлбар, дүгнэлт

Бразил, Исланд, Барселонагийн жишгээс харахад цахим хэлэлцүүлэг, санал асуулга, иргэний санаачилга, танхимын уулзалтыг хослуулах нь оролцооны үр нөлөөг нэмэгдүүлдэг. Төслийн энэ хэсэг нь ийм олон сувгийн оролцооны хандлагатай нийцэж байна.

2.8.4. Нэр томьёо, ухагдахууны тайлбар

“Зөвлөлдөх санал асуулга” гэж эцсийн шийдвэрийг шууд орлохгүй боловч тухайн асуудлаарх иргэдийн байр суурийг тодруулах, шийдвэр гаргалтыг мэдээллээр хангах зорилготой санал авах хэлбэрийг ойлгоно.

Гурав. Төслийн 2 дугаар зүйлийн тайлбар

Төслийн зохицуулалт

Энэ хуулийг 2026 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

3.1. Нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг хойшлуулан тогтоосон үндэслэл, шаардлага

Энэхүү хуулийн хэрэгжилт нь зөвхөн хуулийн текстээс хамаарахгүй бөгөөд дараах бэлтгэл арга хэмжээг шаардана. Үүнд: нийтийн өргөдлийг хүлээн авах цахим системийн бэлэн байдал; тоон гарын үсгийн хэрэглээ, баталгаажуулалтын шийдэл; үлгэрчилсэн журам боловсруулах, батлах; нутгийн өөрөө удирдах байгууллагын албан

хаагчдын чадавх, зохион байгуулалтын бэлтгэл; иргэдэд зориулсан сургалт, сурталчилгаа, хүртээмжийн арга хэмжээ.

Иймд хуулийг батлагдсан даруйд мөрдүүлэх бус, бэлтгэл хангах хугацаа олгож 2027 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжүүлэхээр тогтоож байна.

3.2. Зохицуулалтын агуулгыг хэрхэн ойлгох тухай

Энэ заалт нь хууль батлагдсан өдрөөс бус, заасан өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ гэсэн агуулгатай. Өөрөөр хэлбэл, энэ хугацаанд Засгийн газар журам батлах, холбогдох байгууллагууд техникийн болон зохион байгуулалтын бэлтгэл хангах боломжтой болно.

3.3. Гадаад улсын зохицуулалттай харьцуулсан тайлбар, дүгнэлт

Цахим платформ, баталгаажуулалтын систем нэвтрүүлэхтэй холбоотой хуулиудыг үе шаттайгаар хэрэгжүүлэх нь олон улсад түгээмэл. Техникийн болон институцийн бэлтгэлгүйгээр шууд мөрдүүлэх нь хэрэгжилтийн чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Иймд энэ шийдэл нь практик хэрэгжилтийг хангах үүднээс оновчтой байна.

3.4. Нэр томьёо, ухагдахууны тайлбар

“Дагаж мөрдөнө” гэж тухайн өдрөөс эхлэн хуулийн зохицуулалт албан ёсоор хүчин төгөлдөр үйлчилж эхлэхийг ойлгоно.

Дөрөв. Нэр томьёоны нэгдсэн тайлбар

Хуулийн төслийн зохицуулалтыг нэг мөр ойлгох зорилгоор дараах нэр томьёог нэгдсэн байдлаар тайлбарлав.

Нийтийн өргөдөл: Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар тухайн нэгжийн иргэдийн хамтын санаачилгыг илэрхийлсэн өргөдөл.

Цахим систем: Нийтийн өргөдөл гаргах, нийтлэх, дэмжлэг авах, баталгаажуулах, явцыг хянах, мэдээлэх зориулалттай нэгдсэн цахим орчин.

Тоон гарын үсэг: Цахим гарын үсгийн тухай хуульд заасан, санал өгсөн этгээдийг таних, өгөгдлийн бүрэн бүтэн байдлыг баталгаажуулах цахим баталгаажуулалтын хэрэгсэл.

Хэм хэмжээ тогтоосон шийдвэр: Тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтлэг мөрдөх агуулгатай шийдвэр, журам, тогтоолын шинжтэй шийдвэр.

Хэлэлцэх үүрэгтэй: Холбогдох байгууллага уг асуудлыг албан ёсоор хэлэлцэх асуудалд оруулж, шийдвэрлэх ажиллагаанд авч үзэх үүрэгтэй болохыг илэрхийлнэ. Энэ нь заавал өргөдлийн агуулгаар эцсийн шийдвэр гаргана гэсэн үг биш.

Зөвлөлдөх санал асуулга: Шийдвэр гаргахаас өмнө олон нийтийн байр суурийг тодруулах зорилгоор санал авах хэлбэр.

Тав. Дүгнэлт

Энэхүү хуулийн төсөл нь нутгийн өөрөө удирдах байгууллагын түвшинд иргэдийн оролцоог ерөнхий зарчмын түвшнээс гаргаж, нийтийн өргөдөл гаргах, цахимаар дэмжлэг үзүүлэх, тодорхой босго хангасан тохиолдолд заавал хэлэлцүүлэх эрх зүйн механизмыг бий болгож байгаагаараа ач холбогдолтой.

Төслийн 31 дүгээр зүйлийн шинэчилсэн найруулга нь:

- иргэдийн оролцооны агуулга, хэлбэрийг тодорхой болгох;
- нийтийн болон хувийн шинжтэй өргөдлийн ялгааг зааглах;
- цахим оролцооны баталгаажуулалтыг хуульчлах;
- орон нутгийн шийдвэр гаргалтад олон нийтийн бодит дэмжлэгтэй асуудлыг албан ёсоор авч үзэх нөхцөл бүрдүүлэх;
- зөвлөлдөх оролцооны нэмэлт хэлбэрийг хадгалах

эрх зүйн үр нөлөөтэй байна.

Ингэснээр иргэдийн оролцоо зөвхөн зарчим төдий бус, хуульд суурилсан, хэмжигдэхүйц, хариуцлагатай, ил тод механизмд тулгуурлах бөгөөд нутгийн өөрөө удирдах ёсны агуулгыг бодитоор гүнзгийрүүлэх, орон нутгийн ардчиллыг бэхжүүлэх, шийдвэр гаргалтын чанарыг сайжруулах нөхцөл бүрдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/31 дүгээр зүйл:

“31 дүгээр зүйл. Нутгийн өөрийн удирдлага дахь иргэний оролцоо

31.1. Тухайн нэгжид байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэд сайн дураараа хамтарч тухайн нэгжийнхээ эдийн засаг, нийгмийн тулгамдсан, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар нэг удаагийн, эсхүл хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахыг санаачлах эрхтэй. Энэхүү эрхээ тухайн асуудлаар өргөдөл /цаашид "нийтийн өргөдөл" гэх/ гаргах замаар хэрэгжүүлэх ба нийтийн өргөдлийг цахим системээр гаргаж, хүлээн авч болно.

31.2. Нийтийн өргөдлийг энэ хуулийн 32.8 дахь хэсэгт заасан Иргэдийн нийтийн Хурлын болон 35 дугаар зүйлд заасан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлын хүрээнд гаргана.

31.3. Нутгийн өөрөө удирдах байгууллага дараах үндэслэлээр нийтийн өргөдлийг хүлээн авахгүй:

31.3.1. энэ хуулийн 31.2 дахь хэсэгт заасан асуудлын хүрээнд хамаарахгүй;

31.3.2. улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний аюулгүй байдалд харшилсан;

31.3.3. бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироох, ялгаварлан гадуурхахыг уриалсан;

31.3.4. өргөдөлд дурдсан асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа;

31.3.5. хувийн асуудлаар гаргасан.

31.4. Нийтийн өргөдлийг цахим системд 30 хоногийн хугацаатай байршуулах ба уг өргөдлийг нийслэл, тухайн дүүрэг, хороонд байнга оршин суугаа, Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэдийн 3 хувь ба түүнээс дээш тооны иргэн дэмжсэн, тухайн аймаг, сум, багт байнга оршин суугаа, Монгол Улсын 18 насанд хүрсэн

иргэдийн 5 хувь ба түүнээс дээш тооны иргэн дэмжсэн бол нутгийн өөрөө удирдах байгууллага хэлэлцэх үүрэгтэй:

31.5.Нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.3-т заасан тоон гарын үсгээр баталгаажсан байна.

31.6.Нийтийн өргөдлийг цахим системээр хүлээн авах үлгэрчилсэн журмыг Засгийн газар батална.

31.7.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шаардлагатай гэж үзвэл нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар гаргах шийдвэрийн талаар хуульд заасны дагуу зөвлөлдөх санал асуулга явуулж болно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.15 дахь хэсэг нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.15 дахь хэсэг:

"5.15. Нийтийн өргөдөл гомдлыг цахим системээр хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцох иргэнийг иргэний бүртгэлийн мэдээллийн сантай цахимаар холбон баталгаажуулах бөгөөд иргэний хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангана;"

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны ... дугаар сарын ... -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дараах 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"32.4. Нийтийн өргөдлийг цахим системд 30 хоног байршуулах зохицуулалтаар ил тод байдлыг хангана.;"

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг